



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

Г АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.04.24 № 02/864  
танийн № -т

Г Тушаал, чиглэл хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/51 дүгээр тушаал, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/52 дугаар тушаалыг тус тус хүргүүлж байна.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын бүтэц орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг чиглэл болгож байна.

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/22 дугаар тушаалаар батлагдсан орон тоог бууруулаагүй тул шинэчлэн батлагдсан албан тушаал, орон тооны хязгаарт багтаан хэлтсийн дарга, байцаагч, ажилтнуудыг томилон ажиллуулах, бүтэц орон тоо шинэчлэгдсэн шалтгаанаар албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөхгүй байх.

2. Албан хаагчдыг томилох, албан тушаал өөрчлөх, сэлгэн ажиллуулах, шилжүүлэн ажиллуулах бүтэц зохион байгуулалтын арга хэмжээ авах тохиолдолд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 тоот тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам” болон холбогдох бусад журмыг мөрдлөг болгон шийдвэр гаргах, тухайн албан хаагчтай тохиролцох, зөвшөөрөл авахад анхаарч, баримтаар баталгаажуулах.

3. Албан тушаалтныг томилоходо тухайн албан тушаалын тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавих, боловсролын шаардлагыг хангасан эсэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн чиглэл //хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” тушаалын мэргэжлийн индексийг мөрдөх, албан хаагчийн мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ёс зүй, ажлын үр дүнг харгалзах.

4. Хэлтсийн дарга нарыг томилон ажиллуулахдаа Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай зөвшилцөх.

5. Албан тушаалын тодорхойлолт хэвээр байгаа албан тушаалд томилгоог хийх, албан тушаалын тодорхойлолтын нэр өөрчлөгдсөн боловч чиг үүрэгт өөрчлөлт ороогүй болон шинээр бий болсон албан тушаалд албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл авч батлагдсаны дараа томилгоо хийхийг анхаарах.

6. Сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзول болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу тусгай шалгалтын захиалга өгч, шалгалтыг зарлуулан Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилон ажиллуулах.

7. Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллахаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг хуульд заасан эрх үүргийн хүрээнд НДЕГ-аас баримталж байгаа жишиг тодорхойлолтыг баримтлан батлах, газрын дотоод зохион байгуулалтын нэгжүүдийн чиг үүргийг батлагдсан бүтэц, албан тушаалын тодорхойлолтыг үндэслэн батлах зэрэг болно.

ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА



Б.БАТСҮХ



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 дугаар сарын 08

Дугаар A/51

Улаанбаатар хот

Г Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.1 дэх заалт, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 2.1, 2.2 дахь хэсэг, 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 4 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц батлах тухай” А/19, А/74 дүгээр тушаал, 2024 оны “Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаар батлах тухай” А/45 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын байгууллагын ажлын ачааллыг нягtruулах, үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор тухайн аймгийн хүн ам, ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо болон үйлчилгээний хамрах хүрээг харгалзан “Орхон, Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Аймгийн Нийгмийн даатгалын газрын /тасагтай/ зохион байгуулалтын бүтэц”-ийг гуравдугаар хавсралтаар, “Аймгийн Нийгмийн даатгалын газар /тасаггүй/-ын зохион байгуулалтын бүтэц”-ийг дөрөвдүгээр хавсралтаар, “Аймгийн Нийгмийн даатгалын газрын орон тооны хязгаар”-ыг тавдугаар хавсралтаар, “Аймгийн Нийгмийн даатгалын газар, нэгжүүдийн орон тоо, албан тушаалын жагсаалт”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан нэгжийн дарга, байцаагч, ажилтнуудыг томилон ажиллуулах, нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлахыг аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах зохион

байгуулалтын арга хэмжээ авахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Тамгын газар (Б.Батсүх)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Бүтэц, орон тоо батлах тухай” 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын орон нутгийн салбар нэгжийн бүтэц”-ийн аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст холбогдох хэсэг болон тавдугаар хавсралтаар баталсан “Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн зохион байгуулалтын бүтэц”-ийг бүхэлд нь, мөн тушаалын зургаадугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын орон нутгийн салбар нэгжийн орон тооны дээд хязгаар”-ын аймгийн Нийгмийн даатгалын хэлтэстэй холбогдох хэсгүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
2024 оны 04-дугаар сарын 08-ны өдрийн A/51  
дугаар тушаалын тавдугаар хавсралт

АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРОН  
ТООНЫ ХЯЗГААР



Д/д	Аймгийн нийгмийн даатгалын газрын нэр	Нийт орон тоо	Үүнээс		
			Удирдах	Гүйцэтгэх	Үйлчлэх
1	Архангай аймгийн нийгмийн даатгалын газар	44	4	37	3
2	Баян-Өлгий аймгийн нийгмийн даатгалын газар	38	4	32	2
3	Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын газар	44	4	36	4
4	Булган аймгийн нийгмийн даатгалын газар	40	4	34	2
5	Говь-Алтай аймгийн нийгмийн даатгалын газар	42	4	35	3
6	Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын газар	19	3	13	3
7	Дархан-Уул аймгийн нийгмийн даатгалын газар	43	5	35	3
8	Дорноговь аймгийн нийгмийн даатгалын газар	42	4	35	3
9	Дорнод аймгийн нийгмийн даатгалын газар	40	4	31	5
10	Дундговь аймгийн нийгмийн даатгалын газар	38	4	31	3
11	Завхан аймгийн нийгмийн даатгалын газар	50	4	43	3
12	Орхон аймгийн нийгмийн даатгалын газар	40	5	32	3
13	Өвөрхангай аймгийн нийгмийн даатгалын газар	53	4	44	5
14	Өмнөговь аймгийн нийгмийн даатгалын газар	41	4	35	2
15	Увс аймгийн нийгмийн даатгалын газар	42	4	35	3
16	Төв аймгийн нийгмийн даатгалын газар	54	4	47	3
17	Ховд аймгийн нийгмийн даатгалын газар	46	4	37	5
18	Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газар	45	4	38	3
19	Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын газар	36	4	29	3
20	Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын газар	57	4	47	6
21	Хөвсгөл аймгийн нийгмийн даатгалын газар	53	4	44	5
	Нийт	907	85	750	72

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
2024 оны 04 дугаар сарын 08...-ны өдрийн 16:11  
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



## АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН /ТАСАГГҮЙ/ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Д/д	Нийгмийн даатгалын газрын нэр	Зохион байгуулалтын бүтэц				
1	Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
2	Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
3	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
4	Булган аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
5	Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
6	Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
7	Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
8	Увс аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
9	Төв аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
10	Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	
11	Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа, хяналтын хэлтэс	Санхүү хамралт, бүртгэл, орлогын хэлтэс	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс	

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
2024 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн  
15 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР,  
НЭГЖҮҮДИЙН ОРОН ТОО, АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

9024029135 СТС4666 9081739

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилаал	Орон тоо
<b>Нэг.Удирдлага</b>			<b>1</b>
1	Газрын дарга	T3	1
<b>Хоёр.Захиргаа, хяналтын хэлтэс</b>			<b>11</b>
2	Хэлтсийн дарга	T3	1
3	Хяналт шалгалтын байцаагч	T3	1
4	Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч	T3	1
5	Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн	T3	1
6	Бичиг хэрэг, дотоод асуудал, хөрөнгө хариуцсан мэргэжилтэн	T3	1
7	Мэдээллийн технологийн мэргэжилтэн	T3	1
8	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3	1
9	Архивын ажилтан	TYM	1
10	Үйлчлэгч	TY	1
11	Төсвийн байгууллагын үйлчилгээний ажилтан	TY	2
<b>Гурав. Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэс</b>			<b>7</b>
12	Хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч	T3	1
13	Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн	T3	2
14	Үйл ажиллагааны нягтлан бодогч	TYM	1
15	Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч	T3	2
16	Сайн дурын даатгалын байцаагч	T3	1
<b>Дөрөв. Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс</b>			<b>7</b>
17	Хэлтсийн дарга	T3	1
18	Магадлагч эмч	TY	1
19	Тэтгэвэр, тэтгэмжийн хяналтын байцаагч	T3	1
20	Тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч	T3	3
21	Тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч	T3	1
22	<b>Тав.Сумын байцаагч</b>	T3	<b>18</b>
	<b>Нийт</b>		<b>44</b>